



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 636

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон нийт 13,777,390.00 (арван гурван сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн өрөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001083

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын
газарын 2019 оны дугаар сарын 14-ны
өдрийн дугаар чгтооблын хавсралт



Гэмтэл, согог судалтын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэгдэй нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах автомашини жагсаалт

							XyAanAax AooA Vhnni cahan
							AlooA Vhe
							AY33p TOLTOOHOOp TOLTOOCOOH
							TEB3L-piH 2019 oHpi 244
							YnAaR4an eptet
							XyPmTlRaTcH 3n3R4n
Д/д		Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиллалтад орсон он	Нийт гүйлт /km/			/төгрөгөөр/
1		УАЗ Фургон-22069-033, 39-66 УНМ, суудлын, арагл-50306521, хөдөлгүүр-50447122	2005/2006 135,726	13,777,390.00	13,777,390.00	-	8,000,000 4,000,000
		Нийт дун		13,777,390.00	13,777,390.00	-	4,000,000
				(арван гурван сая долоон зуун далан долоон мянга гурван зуун ерэн)	(найман сая)		(дөрвөн сая)